

СҮХБААТАР АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН
ЗАХИРАГЧИЙН ШИЛЭН ДАНСНЫ ХУУЛИЙН
ХЭРЭГЖИЛТЭД ДОТООД АУДИТ ХИЙСЭН
ТАЙЛАН

2023.12.28

Сүхбаатар аймаг

Нэг. Шалгалтын зорилго

Монгол Улсын Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 8 дугаар зүйлийн 8.2, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журмын 8 дугаар зүйлийн 8.2, 8.5 дахь заалт, аймгийн Засаг даргын баталсан Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2023 онд хийх хяналт шалгалтын төлөвлөгөөг үндэслэн шилэн дансны үйл ажиллагаанд дотоод аудит хийж, дүгнэлт өгөх, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, цаашид үүсэх эрсдэлээс урьдчилан сэргийлж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөхөд оршино.

Хоёр. Шалгалтын бүрэлдэхүүн хугацаа

Аймгийн Санхүүгийн хяналт, дотоодаудитын албаны санхүүгийн хяналт шалгалтыг ахлах дотоод аудитор Х.Хүрэлцэцэг ахалж, дотоод аудитор Б.Уянганям, Дотоод аудитор Б.Цэрэнпагам, дотоод аудитор Б.Буджав нар 2023 оны 12 дугаар сарын 22-ны өдрөөс эхэлж, ажлын 8 хоногт хийж гүйцэтгэлээ.

Гурав. Цар хүрээ, объектын талаарх товч мэдээлэл:

2023 оны 4 дүгээр улирлын байдлаар аймаг, сумын Төсвийн Ерөнхийлөн захирагчийн 136 байгууллагын шилэн дансны цахим хуудсанд Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 2 дугаар зүйлд заасан мэдээллийг хугацаандаа үнэн зөв бүрэн мэдээлсэн эсэх, тайлан илгээлт, хэрэглэгчдийн хувийн мэдээлэл шинэчлэгдсэн эсэх асуудлууд дотоод аудитад хамрагдсан.

Дөрөв. Шалгалтын явцад хийгдсэн ажил, шийдвэрлэсэн асуудал:

Байгууллагуудын шилэн дансанд байршуулсан мэдээллийг, тухайн байгууллагын шилэн дансанд оруулсан байх ёстой мэдээлэлтэй тулган шалгалаа.

Төсвийн Ерөнхийлөн захирагчийн түүний хамрах хүрээний байгууллагуудын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт 2023 оны 12 сарын 01-ны байдлаар нийт 20133 мэдээлэл байршуулахаас 62 хувь буюу 12482 мэдээллийг хуулийн хугацаанд, 38 хувь 7651 мэдээллийг огт оруулаагүй байна. Хуулийн хэрэгжилт 62 хувьтай байна.

Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас Шилэн дансны цахим системд Хөрөнгө оруулалт, тендер, худалдан авах цэс байршуулаагүй, мэдээлэл дутуу болон хугацаа хоцорч мэдээлэл оруулсан, байгууллагын удирдлага, нягтлан бодогч нарт шилэн дансны мэдээллийг цаг хугацаанд нь бүрэн гүйцэт, үнэн зөв мэдээлэх талаар 1-2 удаа анхааруулж, зөвлөмж өгч ажиллалаа. 4 дүгээр улирлын тайланг илгээгүй байна.

Мөн 2023 онд шинээр байгуулагдсан “Сүхбаатар хот байгуулалт орон сууц барилга захиалагч” ОНӨААТҮГ-ыг шилэн дансанд бүртгэл мэдээллээ оруулах талаар удирдлага, нягтлан бодогч нарт зөвлөгөө өгч ажиллалаа.

Тав. Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдал

5.1 Хагас жилийн санхүүгийн тайлан хугацаа хоцроосон 25 байгууллага, огт оруулаагүй 12 байгууллага байна. Үүнээс Дарьганга, Түвшинширээ, Мөнххаан, Наран, Сүхбаатар сумдын Төсвийн төвлөрүүлэн захирагч, Мөнххаан сумын Ерөнхий боловсролын сургууль, Сүхбаатар ойжуулалт, Уулбаян сумын ИТХ, Эрүүл мэндийн төв, Дарьганга тохижилт, Түмэнцогт ус дулаан ОНӨААТҮГ байгууллага байна.

5.2 Худалдан авах ажилагааны төлөвлөгөө оруулаагүй 16 байгууллага байна. Үүнд: Дарьганга сумын Ерөнхий боловсролын сургууль, Хүүхдийн цэцэрлэг, Насан туршийн боловсрол төв, Сүхбаатар сумын Засаг даргын Тамгын газар, Ерөнхий боловсролын сургууль, Сүхбаатар нийтлэг үйлчилгээ, Сүхбаатар ойжуулалт, Уртын гэгээ ОНӨААТҮГ, Уулбаян сумын ИТХ, Эрүүл мэндийн төв, Халзан сумын Эрүүл мэндийн төв, Биеийн тамир, спортын газар, Түмэнцогт сумын ИТХ, Соёлын төв, Түмэнцогт ОНӨҮГ, Түмэнцогт ус дулаан ОНӨААТҮГ

5.3 Батлагдсан төсвийн мэдээллийг хугацаа хоцроосон Сүхбаатар сумын Эрүүл мэндийн төв, Онгон сумын Соёлын төв, Халзан сумын Соёлын төв, Баруун-Урт цэцэрлэгжүүлэлт ОНӨААТҮГ 4 байгууллага, огт оруулаагүй Дарьганга сумын Эрүүл мэндийн төв, Наран сумын Молцог илч ОНӨААТҮГ, Сүхбаатар сумын төсвийн төвлөрүүлэн захирагч, Халзан сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал 4 байгууллага байна.

5.4 Дараа жилийн төсвийн төслийг хугацаа хоцроосон 34 байгууллага, огт

оруулаагүй 9 байгууллага байна. Үүнд: Түвшинширээ, Наран, Сүхбаатар сумдын төсвийн төвлөрүүлэн захирагч, Түвшинширээ сумын ЕБС, Насан туршийн боловсрол төв, Наран сумын ИТХ, Сүхбаатар ойжуулалт ОНӨААТҮГ, Уулбаян сумын ИТХ, Түмэнцогт ус дулаан ОНӨААТҮГ

5.5 Хандив, тусламжийн орлого, зарцуулалтын тайланг хугацаа хоцроосон 12, огт оруулаагүй 10, Үүнд: Сүхбаатар сумын ЕБС, Сүхбаатар ойжуулалт ОНӨААТҮГ, Онгон сумын ЕБС, Эрүүл мэндийн төв, Уулбаян сумын ИТХ, Эрүүл мэндийн төв, Дарьганга тохижилт, Онгон-Арвижих, Халзан дулаан, Түмэнцогт ус дулаан ОНӨААТҮГ

5.6 Өмнөх оны төсвийн зарлагын хэмнэлт, туслах үйл ажиллагааны орлогоос давсан хэсгийг урамшуулалд зарцуулсан тайлан огт оруулаагүй 18 байгууллага байна. Үүнд: Түвшинширээ сумын ИТХ, Насан туршийн боловсрол төв, Сүхбаатар сумын ЕБС, Сүхбаатар нийтлэг үйлчилгээ, Сүхбаатар ойжуулалт, Уртын гэгээ, Молцог илч, Баруун-Урт цэцэрлэгжүүлэлт, Дарьганга тохижилт, Онгон-Арвижих, Халзан дулаан, Түмэнцогт ус дулаан ОНӨААТҮГ, Дөрвөлж ОНӨҮГ, Онгон сумын ЕБС, Эрүүл мэндийн төв, Уулбаян сумын ИТХ, Эрүүл мэндийн төв,

Зургаа. Дүгнэлт, цаашид авах арга хэмжээний санал:

Төсвийн шууд захирагч болон ОНӨҮГ-ын дарга удирдлага, санхүүгийн бүртгэлийн ажилтнууд шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шуурхай хангаж, шилэн дансны цахим хуудсанд байршуулах мэдээллийг стандартын дагуу, үнэн зөв, бодитой, иж бүрэн, тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлж хэвших Шилэн дансны тухай хуулийн 8.1-д энэ хуулийн 3.1-д заасан этгээдийн шилэн дансны үйл ажиллагаанд тавих хөндлөнгийн хяналтыг бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, иргэдийн Нийтийн Хурал, төрийн аудитын байгууллага хэрэгжүүлнэ гэж заасны дагуу шат шатны иргэдийн ИТХ нь хяналтаа тавьж, хуулийн хэрэгжилтийг хангуулж ажиллах шаардлагатай байна.

ТАЙЛАН БИЧСЭН:

ДОТООД АУДИТОР

Б. БУДЖАВ

